



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын “Уян сэтгэл” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өвөрхангай аймаг Арвайхээр сум 2022 он</p>	<p>Өвөрхангай аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Гансүх Утас: 99328832 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com</p> <p>Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг:</p> <p>Аудитор: Д.Дашзэвэг Утас: 95329926 Цахим хаяг: dashzeveg_d@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

догоо. 02. 25 № 311

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ



015030626

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4784083.15</b>	<b>76644496.84</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	30083.15	59796.29
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	30083.15	59796.29
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	30083.15	59796.29
31211	Төрийн сангийн харилцах	30083.15	59796.29
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.00	71559276.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	682279.32
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	0.00	70876997.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	69676997.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	1200000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	4754000.00	5025424.23
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	4754000.00	5025424.23
35130	Эм боох материал	4754000.00	5025424.23
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>287340701.70</b>	<b>313935838.41</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	287340701.70	313935838.41
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	272271326.70	298545838.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	274800000.00	274800000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48090000.00	-61830000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21916666.00	21916666.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9861717.82	-12343333.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	49684828.33	98267333.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30458181.37	-36988428.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28965748.71	33371748.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14686017.15	-18648148.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	550000.00	550000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	15069375.00	15390000.00
39301	Програм хангамж	423600.00	423600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-423600.00	-423600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15390000.00	15390000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-320625.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>292124784.85</b>	<b>390580335.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>8504139.00</b>	<b>600000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	8504139.00	600000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	8504139.00	600000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4265659.00	600000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1338480.00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2900000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2900000.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>283620645.85</b>	<b>389980335.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	283620645.85	389980335.25

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	74025640.00	74025640.00
51101	Өмч: - төрийн	74025640.00	74025640.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>159138450.49</b>	<b>265498139.89</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	159138450.49	159459075.49
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	106039064.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50456555.36	50456555.36
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>292124784.85</u></b>	<b><u>390580335.25</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>276679100.00</b>	<b>940507983.79</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>405800628.79</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>405800628.79</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	405800628.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14000000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	391800628.79
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>276679100.00</b>	<b>534707355.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>273524100.00</b>	<b>318943416.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273524100.00	318943416.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3155000.00</b>	<b>36459966.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3155000.00	35459966.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>179303973.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	179303973.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>280529760.87</b>	<b>834468919.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>280529760.87</b>	<b>834468919.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>278608580.87</b>	<b>783475919.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>187476779.85</b>	<b>264643203.54</b>
210101	Үндсэн цалин	187476779.85	264643203.54
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10437004.00</b>	<b>31658992.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	6806742.00	15439886.00
210202	Тэтгэмжийн даатгал	726052.00	3919106.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	907566.00	4454799.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181513.00	1345201.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1815131.00	6500000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12033930.00</b>	<b>12731198.00</b>

210301	Гэрэл, цахилгаан	1268560.00	1430106.00
210302	Түлш, халаалт	10038600.00	11243232.00
210303	Цэвэр, бохир ус	726770.00	57860.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19546659.00</b>	<b>25630279.00</b>
210401	Бичиг хэрэг	3882600.00	11167350.00
210402	Тээвэр, шатахуун	2025450.00	3802400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997756.00	2681021.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал	0.00	480000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12640853.00	7499508.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18808525.00</b>	<b>388736429.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13839525.00	378276929.00
210502	Хоол, хүнс	0.00	2000000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4969000.00	8459500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>3660550.00</b>
210604	Урсгал засвар	0.00	3660550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>760000.00</b>	<b>1691138.00</b>
210702	Дотоод албан томиллолт	760000.00	1691138.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1451639.00</b>	<b>28010136.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1029300.00	27527916.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98339.00	174420.00
210807	Газрын төлбөр	0.00	307800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28094044.02</b>	<b>26713993.85</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28094044.02	26713993.85
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1921180.00</b>	<b>50993000.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1921180.00	50993000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1921180.00	50993000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-3850660.87</b>	<b>106039064.40</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-3850660.87</b>	<b>106039064.40</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	159,138,450.49	283,620,645.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	159,138,450.49	283,620,645.85
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	159,138,450.49	283,620,645.85

D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	159,138,450.49	283,620,645.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	320,625.00	320,625.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	159,459,075.49	283,941,270.85
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	106,039,064.40	106,039,064.40
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,025,640.00	50,456,555.36	265,498,139.89	389,980,335.25

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>276679100.00</u>	<u>548707355.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	14000000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	14000000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	14000000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	14000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	276679100.00	534707355.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	273524100.00	318943416.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	273524100.00	318943416.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3155000.00	36459966.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3155000.00	35459966.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	179303973.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	179303973.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>276672902.85</u>	<u>513255643.86</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276672902.85	513255643.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274751722.85	462262643.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198074045.85	273091141.86
210101	Үндсэн цалин	198074045.85	273091141.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10437004.00	31658992.00
210201	Тэтгэврийн даатгал	6806742.00	15439886.00
210202	Тэтгэмжийн даатгал	726052.00	3919106.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	907566.00	4454799.00

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

210204	Ажилгүйдлийн даатгал	181513.00	1345201.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1815131.00	6500000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10695450.00</b>	<b>14069678.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1268560.00	1430106.00
210302	Түлш, халаалт	8700120.00	12581712.00
210303	Цэвэр, бохир ус	726770.00	57860.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25476607.00</b>	<b>21450379.00</b>
210401	Бичиг хэрэг	6177600.00	4617350.00
210402	Тээвэр, шатахуун	2025450.00	3802400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997756.00	2681021.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	480000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16275801.00	9869608.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25136977.00</b>	<b>90556729.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19777825.00	81717229.00
210502	Хоол, хүнс	390152.00	380000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4969000.00	8459500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2720000.00</b>	<b>1734450.00</b>
210604	Урсгал засвар	0.00	1734450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>760000.00</b>	<b>1691138.00</b>
210702	Дотоод албан томилолт	760000.00	1691138.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1451639.00</b>	<b>28010136.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1029300.00	27527916.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98339.00	174420.00
210807	Газрын төлбөр	0.00	307800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1921180.00</b>	<b>50993000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1921180.00</b>	<b>50993000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1921180.00	50993000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6197.15</b>	<b>35451711.14</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>35421998.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>35421998.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>35421998.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	35421998.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-35421998.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>6197.15</b>	<b>29713.14</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>30083.15</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6197.15</b>	<b>59796.29</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны төлөвлөгөө	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	276672890.00	276672902.85	548677640.00	548677641.86
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	276672890.00	276672902.85	548677640.00	548677641.86
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	274751710.00	274751722.85	497684640.00	497684641.86
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	198074040.00	198074045.85	273091140.00	273091141.86
210101	Үндсэн цалин	198074040.00	198074045.85	273091140.00	273091141.86
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10436990.00	10437004.00	31658980.00	31658992.00
210201	Тэтгэврийн даатгал	6806740.00	6806742.00	15439880.00	15439886.00
210202	Тэтгэмжийн даатгал	726050.00	726052.00	3919110.00	3919106.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	907560.00	907566.00	4454790.00	4454799.00
210204	Ажилгүйдлийн даатгал	181510.00	181513.00	1345200.00	1345201.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1815130.00	1815131.00	6500000.00	6500000.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10695450.00	10695450.00	14069680.00	14069678.00
210301	Гэрэл, цахилгаан	1268560.00	1268560.00	1430110.00	1430106.00
210302	Түлш, халаалт	8700120.00	8700120.00	12581710.00	12581712.00
210303	Цэвэр, бохир ус	726770.00	726770.00	57860.00	57860.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25476610.00	25476607.00	29646380.00	29646379.00
210401	Бичиг хэрэг	6177600.00	6177600.00	11167350.00	11167350.00
210402	Тээвэр, шатахуун	2025450.00	2025450.00	3802400.00	3802400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	997750.00	997756.00	2681020.00	2681021.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00	480000.00	480000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16275810.00	16275801.00	11515610.00	11515608.00
2105	<b>Нормативт зардал</b>	25136980.00	25136977.00	90556730.00	90556729.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19777830.00	19777825.00	81717230.00	81717229.00
210502	Хоол, хүнс	390150.00	390152.00	380000.00	380000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4969000.00	4969000.00	8459500.00	8459500.00

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2720000.00	2720000.00	28960450.00	28960448.00
210602	Тавилга	2720000.00	2720000.00	27226000.00	27225998.00
210604	Урсгал засвар	0.00	0.00	1734450.00	1734450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	760000.00	760000.00	1691140.00	1691138.00
210702	Дотоод албан томилолт	760000.00	760000.00	1691140.00	1691138.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1451640.00	1451639.00	28010140.00	28010136.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1029300.00	1029300.00	27527920.00	27527916.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	324000.00	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98340.00	98339.00	174420.00	174420.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00	307800.00	307800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1921180.00	1921180.00	50993000.00	50993000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1921180.00	1921180.00	50993000.00	50993000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1921180.00	1921180.00	50993000.00	50993000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		23886.00	0.00	30083.15
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.0	30083.15	0.00	59796.29

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>50,459,966.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>50,459,966.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>21,659,966.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>0.00</b>	<b>5,430,828.00</b>
210101	Үндсэн цалин		5,430,828.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>6,740,000.00</b>
210401	Бичиг хэрэг		6,740,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>1,620,000.00</b>
210502	Хоол, хүнс		1,620,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>1,229,138.00</b>

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

210702	Дотоод албан томилолт		1,229,138.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	6,640,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,640,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	28,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	28,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		28,800,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	50,459,966.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	50,459,966.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		35,459,966.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		14,000,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дашзэвэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д. Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Арвайхээр сумын Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дөлгөөнхайрхан Уул Аудит ХХК-д 2022 оны 02 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

**Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:**

Арвайхээр сумын Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6.1.2-д заасан "эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх

холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах” гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арвайхээр сумын Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 905,3 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тайлант онд 391730,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан бол 27568,1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 25420,4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор тус тус нэмэгдэж 444719,3 мянган төгрөгийн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын хувьд 4754,0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 116164,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 366038,1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй авч, 481930,7 мянган төгрөг зарцуулж 5025,4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оны эцэст авлагагүй байсан бол тайлант оны эцэст

70359,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өглөг өмнөх оны эцэст 8504,1 мянган төгрөг байсан бол оны эцэст өглөггүй тус тус гарсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төлөвлөгөөгөөр цалинд 273091,0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 31659,0 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 14070,0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 29646,4 мянган төгрөг, эм, хоол, нормын хувцас зэрэг нормативт зардалд 90556,7 мянган төгрөг, мянган төгрөг, зардалд мянган төгрөг, зардалд мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 50993,0 мянган төгрөг, бусад урсгал зардалд 31435,7 мянган төгрөг нийт урсгал зардалд 513255,6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр цалингийн зардалд 273091,1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 31659,0 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 14069,7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 21450,4 мянган төгрөг, эм, хоол, нормын хувцас зэрэг нормативт зардалд 90556,7 мянган төгрөг, мянган төгрөг, зардалд мянган төгрөг, зардалд мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 50993,0 мянган төгрөг, бусад урсгал зардалд 31435,7 мянган төгрөг нийт урсгал зардалд 513255,6 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 59,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 50460,0 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсгийн талаар тодруулах мэдээлэл байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нэвтэрч оруулах ёстой мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг шалгахад нийт 119 мэдээлэл оруулахаас 50 мэдээллийг хугацаа хожимдуулан оруулсан байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

Коронавируст халдвар (covid-19)-аар өвчилсөн иргэдэд гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, зарцуулалтыг анхан шатны баримт эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн бүртгэлийг гаргуулан шалгахад: Тус эмнэлэг нь 2021 онд ковидоор хөнгөн өвчилсөн 1158 хүнийг гэрээр тусламж үйлчилгээнд хамруулж эрүүл мэндийн даатгалын сангаас 148450,0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 85.950.5 төгрөгийн санхүүжилт авч 62499,5 мянган төгрөгийн санхүүжилтийн дутууг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд хийгдсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт өгсөн ба анхан шатны бүртгэл хөтлөлт, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэгт зөвлөмж өгсөн хэрэгжилт хангалтгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд үүссэн материаллаг дүнтэй авлагын асуудлыг анхаарах шаардлагатай.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 5,3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 0,3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 3,8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, аудитаар илэрсэн 3 алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн болно.

### **4,1 Төлбөрийн акт**

Тайлант онд ээлжийн амралтын цалингийн дүнд хоолны хөнгөлөлтийг оруулж тооцсоноос 320,3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь: Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 5-р сарын 5-ны өдрийн 55 тоот тушаалаар баталсан дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4-д “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй.” гэж заасантай нийцэхгүй байна.

### **4,2 Аудитын залруулга**

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ

Тайлант онд 4 хүнд 2950,0 мянган төгрөгийн урьдчилгаа олгоод 1750,0 мянган төгрөгийг суутгаж 1200,0 мянган төгрөгийг суутгаагүй, жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь: Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 4-ийн 8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ". 14,4,2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

#### **4.3 Албан шаардлага**

Шатахууны зардалд 3802,4 мянган төгрөгийн зардал гаргасан боловч жолоочийн тооцооны хуудсыг хөтөлснөөс өөр баримтгүй, сар бүр шатахууны тайланг гаргаагүй, тооцоог бодоогүй байна.

Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан: Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 3-ийн 9-д "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### **4.4 Зөвлөмж**

##### **1. Анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Тус байгууллагын эд хариуцагч нь бараа материалын орлого зарлагын падаан хөтөлдөггүй, эм болон бусад бараа материалын тайланг сар улирлаар гаргадаггүй, жилээр ганц удаа гаргасан боловч шаардах хуудсыг тухайн тайландаа хавсаргаагүй бөөнд нь хавсаргасан. Бараа материалын тайланд хавсаргасан баримтын тоо хэмжээ тавиагүй нягтлан бодогч хянаж гарын үсэг зураагүй. Шаардах хуудас болон орлого, зарлагын баримтыг урьдчилан дугаарлаагүй. Тооллогын комисс нь тооллогын бүртгэлийг хөрөнгө, бараа материалын нэр төрлөөр хөтлөөгүй зөвхөн ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлээр хийсэн. Нягтлан бодогч нь тооллогын дүнг гаргаж эд хариуцагчийн тооцоог бодоогүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13-р зүйлийн 5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", мөн хуулийн 13-р зүйлийн 7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72-р зүйлийн 1-ийн 4-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримт хөтлөх, хөрөнгө бараа материалын тайланг гаргахдаа Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 -р тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааварт заасны дагуу хөтөлж, тайланг гаргаж байх, тооллогын бүртгэлийн хөрөнгө, бараа материалын нэр төрлөөр гаргаж тооцоог бодуулж байхыг тус тус зөвлөмж болгов.

## 2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

### 2.1 Илрүүлэлт:

“Уян сэтгэл” ӨЭМТөвийн Шилэн дансны цахим хуудсанд нэвтэрч оруулах ёстой мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг шалгахад нийт 119 мэдээлэл оруулахаас 50 мэдээллийг хугацаа хожимдуулан оруулсан байна.

### 2.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хугацаа хожимдуулалгүй оруулж байх

## 3. Дотоод хяналт шалгалттай холбоотой асуудал

### 3.1 Илрүүлэлт:

“Уян сэтгэл” ӨЭМТөв нь өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтын журам боловсруулж мөрдөөгүй байна.

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолын хавсралтаар баталсан нийтлэг журмын дагуу өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам” боловсруулж батлуулан мөрдөх

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Арвайхээр сумын Уян сэтгэл Өрхийн эрүүл мэндийн төв	6	5,3	1	1,2	1	0,3	1	3,8	3	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Д.ДАШЗЭВЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 25-НИЙ ӨДӨР

Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ТШЗ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18А-2022/1НН-СТА-ТМБ/18425219/13 Арвайхээр

Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч. Сэрчмаа танаа

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Санхүүгийн тайлангийн аудитаар ээлжийн амралтын цалингийн дүнд хоолны хөнгөлөлтийг оруулж тооцсоноос 320,3 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих," Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 5-р сарын 5-ны өдрийн 55 тоот тушаалаар баталсан дундаж цалин хөлс тодорхойлох журмын 4-д "Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ыг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Аудитаар илэрсэн ээлжийн амралтын цалингийн дүнд хоолны хөнгөлөлтийг оруулж тооцсоноос 320,3 мянган төгрөгийн илүү олгосон цалинг холбогдох хүмүүсээр төлүүлж Төрийн сан дахь Орон нутгийн ерөнхий орлогын 100100000910 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Сэрчмаа, нягтлан бодогч А.Туяамаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ  
ДӨЛГӨӨНХАЙРХАН-УУЛ АУДИТ ХХК-ЫН  
АУДИТОР  Д.ДАШЗЭВЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 111А-2022/111А-ОТА-ТМБ/15723219/2022  
Арвайхээр

Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Сэрчмаа танаа

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Шатахууны зардалд 3802,4 мянган төгрөгийн зардал гаргасан боловч жолоочийн тооцооны хуудсыг хөтөлсөнөөс өөр баримтгүй, сар бүр шатахууны тайланг гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй байна.


Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан: Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 3-ийн 9-д "Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан шатахууны зардалд 3802,4 мянган төгрөгийн зардал гаргасан боловч жолоочийн тооцооны хуудсыг хөтөлснөөс өөр баримтгүй, сар бүр шатахууны тайланг гаргаагүй, жолоочийн тооцоог бодоогүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр сумын "Уян сэтгэл" Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Ч.Сэрчмаа, нягтлан бодогч А.Туяамаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ  
ДӨЛГӨӨНХАЙРХАН-УУЛ АУДИТ ХХК-ЫН  
АУДИТОР  Д.ДАШЗЭВЭГ